

4

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ БОДЛОГЫГ БОЛОВСРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ

3.Бороо

Гадаадын хөрөнгө оруулалтыг нэг сумаар таван туулай агнахтай адилтгах болсон энэ үед түүнийг дэмжиж ашиглах үйл ажиллагааг хэрхэн төлөвлөх буюу гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлогыг хэрхэн боловсруулах тухай асуудал нэн тэргүүнд тавигдана. Үүний тулд юун түрүүнд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа гэж юу болох, түүний бодлого гэж юуг хэлдэг болох, ямар онцлогтой зүйл болох талаар тодорхой ойлголттой байх шаардлагатай. Мөн гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлогыг ямар үе шаттайгаар хэрхэн боловсруулах, энэ явцдаа юуг анхаарах талаар ч бас мэдэх шаардлагатай. Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалтад нааштай хандаж, түүнийг дэмжиж ашиглах үйл ажиллагааг идэвхтэй явуулж буй энэ үед зохих хэмжээгээр тусгалаа олоосой гэсэн үүднээс энэхүү судалгааг хийлээ.

1. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлогын орчин

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа гэж “Хөрөнгө оруулалт хийж байгаа болон авч байгаа талуудын шаардлага хэрэгцээг хангах зорилгоор гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих цогц арга хэмжээ”-г хэлнэ. Улмаар гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлогыг “Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааг бодитоор хэрэгжүүлэх үйл хөдлөлийн төлөвлөгөө буюу гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааг чиглүүлэх объектыг тодорхойлох, эдгээрт хэрэгтэй хөрөнгө оруулалтыг бий болгох арга замыг боловсруулж хэрэгжүүлэх ажиллагаа” гэж тодорхойлж болно.

1) Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлогын агуулга

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа дараах гурван бодлоготой нягт уялдаатай байдаг. Нэгдүгээрт гадаад валютын тогтвортой байдал, олон улсын төлбөрийн тэнцэл, ажил эрхлэлт, эдийн засгийн өсөлт гэх мэт макро эдийн засгийн бодлого. Хоёрдугаарт аж үйлдвэрийн бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлох аж үйлдвэрийн бодлого. Гуравдугаарт компанийн бүтэц, өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн аж ахуйн нэгжийн бодлого болно.

■ Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлого ба макро эдийн засгийн бодлого

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа нь гадаад валютын тогтвортой байдал, олон улсын төлбөрийн тэнцэл, ажил эрхлэлт болон эдийн засгийн өсөлт гэх мэт макро эдийн засгийн хүчин зүйлст нөлөө үзүүлдгээрээ энэ үйл ажиллагааны бодлого нь тухайн орны макро эдийн засгийн бодлоготой салшгүй холбоотой байдаг. Энэ талаар тодруулахад гадаадын хөрөнгө оруулалт нь валютын нөөц багатай орны хувьд өр төлбөргүй, гадаад валютыг найдвартай нийлүүлэгч эх сурвалж болдог байна. Жишээ нь: Солонгос улс Азийн санхүүгийн хямралд орсон үед гадаадын хөрөнгө оруулалт гадаад валютын эрэлт нийлүүлэлтийн тэнцвэртэй байдал бий болоход ихээхэн нөлөө үзүүлж байв. Гадаадын хөрөнгө оруулалтаар ажлын байр бий боллогоос үүнийг ажил эрхлэлтийн бодлогын арга хэрэгслээр ашигладаг байна. Үүнийг нүүрс олборлолтын үйлдвэрлэл нь уналтад орсноос их хэмжээний ажилгүйдэл бий болсон үед Английн засгийн газар гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхтэй ашиглаж байсан явдал багтана. Үүнээс гадна гадаадын хөрөнгө оруулалтыг экспортыг дэмжих бодлогын арга хэрэгслээр ашиглах нь бий. Өнөөдөр дэлхийн олон оронд экспортын үйл ажиллагаатай гадаадын компаниудын хөрөнгө оруулалтыг дэмжих арга хэмжээ (татвараас хөнгөлөх, чөлөөт худалдааны бүс байгуулах гэх мэт)-г идэвхтэй авч хэрэгжүүлж байгаагаар үүнийг нотлож болно.

■ Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлого ба аж үйлдвэрийн бодлого

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа макро эдийн засгийн бодлогоос гадна аж үйлдвэрийн бодлоготой нягт холбоотой. Солонгос, Хятад гэх мэт азийн орнуудад аж үйлдвэр хөгжихөд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлого чухал үүрэг гүйцэтгэж байжээ

Аж үйлдвэрийн бодлогыг янз бүрээр тайлбарладаг хэдий ч ерөнхийд нь аж үйлдвэрийн бүтцийн бодлого болон аж үйлдвэрийн зохион байгуулалтын бодлогод хувааж авч үздэг.¹⁸ Аж үйлдвэрийн бүтцийн бодлого гэж аж үйлдвэрийн дотоод (intra-industry) бүтцэд оролцох замаар буюу тухайн аж үйлдвэрт үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулдаг хүчин зүйлсийг шийдвэрлэх монополь, олигополь эрхтэй компаниудын зүй бус үйлдэлд хязгаарлалт хийх замаар зах зээлийн бүтэц тогтолцоог үр ашигтай болгох өрсөлдөөнийг дэмжсэн бодлогыг хэлнэ. Харин аж үйлдвэрийн зохион байгуулалтын бодлого гэж эдийн засгийн бүтээмж өндөртэй аж үйлдвэрийн бүтцийг төлөвлөж бүрдүүлэх үүднээс аж үйлдвэр хооронд (inter-industry)-ын нөөцийн хуваарилалтыг зохицуулах бодлогыг хэлнэ. Аж үйлдвэрийн бүтцийн бодлогыг дахин тодорхой нэг салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн аж үйлдвэрийг дэмжих бодлого болон уналтанд орсон аж үйлдвэрийн бүтцийг сайжруулах, мөн илүүдэл хөрөнгө оруулалтад хязгаарлалт хийх аж үйлдвэр зохицуулалтын бодлогод хуваадаг.

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа аж үйлдвэрийн бүтцийн бодлогын хэрэгжилтэнд шууд хэлбэрээр, аж үйлдвэрийн зохион байгуулалтын бодлогын хэрэгжилтэнд шууд бус хэлбэрээр нөлөө үзүүлнэ. Нэг ёсондоо гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлого аж үйлдвэрийн бүтцийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл болдог гэсэн үг. Аж үйлдвэрийг дэмжих бодлогод гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа нь тухайн аж үйлдвэрийн салбарт нэмүү өртөг өндөртэй, дэвшилтэт технологи нэвтрүүлснээр түүний хөгжлийг дэмжиж олон улсын зах зээл дээрх өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх үүрэгтэй. Хөгжиж буй орнууд шинэ технологи нээж нэвтрүүлэх боломжоор багатай байдгаас өндөр хөгжсөн, урдаа барьдаг аж үйлдвэрийнхээ салбарт үндэстэн дамнасан корпорацийн хөрөнгө оруулалтыг бий болговол тухайн аж үйлдвэрийн салбар нь цар хүрээгээ тэлж хөгжих жишээтэй. Харин аж үйлдвэр зохицуулалтын бодлогод гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа нь компаний менежментийг шудрагаар явуулах, өрсөлдөөний арга барил эзэмшүүлэх, дэлхийн төвшинд хүрч ажиллах гэх мэт өндөр хөгжилтэй орны зах зээлийн үндсэн зарчмыг нэвтрүүлж тухайн орны зах зээлийн бүтээмжийг нэмэгдүүлэх үүрэгтэй байдаг. Энэ бодлогыг хэрэгжүүлэхэд M&A хэлбэрийн гадаадын хөрөнгө оруулалт тохиромжтой байдаг. M&A хэлбэрийн хөрөнгө оруулалт зардал хэмнэх эдийн засгийн зарчмын дагуу ач холбогдол бий болгоод зогсохгүй үндэстэн дамнасан корпорацийн менежментийн ноу хау, брэнд гэх мэтийг нэвтрүүлдэгээс M&A хийгдсэн компаний өрсөлдөх чадвар нэмэгдэх жишээтэй.

■ Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлого ба аж ахуйн нэгжийн бодлого

¹⁸ 조동성, 1994, 『한일산업정책 연구』, 국제기업전략연구소, p.19.

Аж ахуйн нэгжийн төвшинд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа ихэнх тохиолдолд үндэстэн дамнасан корпорацийн дэвшилтэт технологи, менежментийн ноу хауг нэвтрүүлэхэд чиглэдэг. Энэ үйл ажиллагаа зарим тохиолдолд муу ажиллагаатай аж ахуйн нэгжид зохицуулалт хийх засгийн газрын бодлогын дагуу явагдах нь бий. Тухайлахад Азийн санхүүгийн хямралын үеэр Солонгосын Засгийн газар компаниудын санхүүгийн бүтэц, менежментийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн компаний бүтэц зохицуулалтын бодлогыг авч хэрэгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалт багагүй үүрэг гүйцэтгэж байжээ.


2) Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлогын орчин

Эдийн засгийн бодлогын орчин болон гадаадын хөрөнгө оруулалтын орчин гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлоготой салшгүй холбоотой. Эдийн засгийн бодлогын орчин болон гадаадын хөрөнгө оруулалтын орчин гэж юуг хэлдэг, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны зорилт; түүнд хүргэх арга хэрэгсэлтэй хэрхэн хамааралтай болох талаар авч үзье.

1. Эдийн засгийн бодлогын орчин ба гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны зорилт: Аливаа орны засгийн газар ажил эрхлэлт, гадаад валютын тогтвортой байдал, олон улсын төлбөрийн тэнцэл, аж үйлдвэрийн бүтцийн зохицуулалт, компаний бүтцийн шинэчлэл гэх мэт макро эдийн засгийн бодлого, аж үйлдвэрийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэх үүднээс гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааг авч явуулдаг. Тиймээс гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлого аливаа орны эдийн засгийн бодлогын салбар ухагдахуун болдог бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны зорилт тухайн орны эдийн засгийн зорилтуудын нэг болдог.
2. Эдийн засгийн бодлогын орчин ба гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны арга хэрэгсэл: Эдийн засгийн бодлоготой уялдаатай гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны арга хэрэгсэлд татвар бууруулах, мөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх, түрээсийн төлбөрийг багасгах гэх мэт хөрөнгө оруулалтын ин센див орно.
3. Гадаадын хөрөнгө оруулалтын орчин ба гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны арга хэрэгсэл: Ихэнх тохиолдолд жижиг зах зээлтэй, үйлдвэрлэлийн бүтээмж муутай улс орнууд хөрөнгө оруулалтын инсендивийг санал болгодог. Тиймээс гадаадын хөрөнгө оруулалтын орчныг гадаадын хөрөнгө

4. оруулалтыг дэмжих үйл ажиллагааны арга хэрэгслийг тодорхойлогч хүчин зүйл гэж үзэж болно.
5. Гадаадын хөрөнгө оруулалтын орчин ба гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны зорилт: Гадаадын хөрөнгө оруулалтын орчин сайн байхад гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлогын зорилтыг тодорхойлоход хүндрэл бага гарна. Техник технологи өндөр хөгжсөн оронд дэвшилтэт аж үйлдвэрийг хөгжүүлэхэд чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны зорилт хэрэгжихэд харьцангуй хялбар. Харин хөрөнгө оруулалтын орчин тааруухан бол гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны зорилтыг тодорхойлоход хүндрэлтэй. Ийм үед гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны зорилт хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад чиглэдэг. Тухайлбал зах зээлийн өрсөлдөөн багатай улс зах зээлийн өрсөлдөөнийг идэвхжүүлэх, өрсөлдөөний шударга байдлыг хүчжүүлэх зорилгоор гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлогын орчин



Эх: Sunghoon Lim, *Strategic Foreign Direct Investment Marketing*, Hakhyongsa, 2004, p.40.

2. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлогын зорилт, түүнд хүрэх арга хэрэгсэл

1) Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны зорилтыг тодорхойлох

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлого боловсруулах хамгийн эхний шатанд гадаадын хөрөнгө оруулалтыг ач

холбогдолтой ашиглах чиглэл буюу гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны зорилтыг тодорхойлох ёстой. Гадаадын хөрөнгө оруулалт эдийн засгийн өндөр ач холбогдолтой гэсэн шалтгаанаар эдийн засгийн бодлогын бүх зорилтыг гадаадын хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зорилттой уялдуулж болохгүй. Энд эдийн засгийн бусад зорилтуудтай зөрчилдөхгүй, гадаадын хөрөнгө оруулалтын эдийн засгийн ач холбогдлыг хамгийн дээд хэмжээнд бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны зардлыг хамгийн доод хэмжээнд байлгах, эдийн засгийн бодлоготой уялдуулах нь чухал. Түүний дараа энэ зорилтыг хэрэгжүүлэхэд хэрэглэх арга хэрэгслийг тодорхойлно. Ямар арга хэрэгслийг төлөвлөж, хэрхэн ашиглахаас хамаарч гадаадын хөрөнгө оруулалтын эдийн засгийн ач холбогдлын хэмжээ янз бүр байна.

1. **Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны зорилтыг тодорхойлох:** Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны зорилтыг гадаадын хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх эдийн засгийн асуудалтай уялдуулж тодорхойлно.
2. **Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны арга хэрэгслийг тодорхойлох:** Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны арга хэрэгслийг эдийн засгийн бодлогын зорилтыг хэрэгжүүлэх засгийн газрын үйл ажиллагаа, арга хэмжээний хүрээнд тодорхойлно.
3. **Зорилт, түүнд хүргэх арга хэрэгсэл хоорондын тохироог бий болгох:** Хөрөнгө оруулалтын ин센див зэрэг хөрөнгө оруулалтын арга хэрэгсэл гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны зорилт биелэлээ олоход тохирч байгаа эсэхийг тодорхойлно.

2) *Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны арга хэрэгслийг тодорхойлох*

■ **Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны арга хэрэгслийн төрөл**

Эдийн засгийн бодлогын арга хэрэгсэл дэмжих болон хязгаарлах гэсэн хоёр хэлбэртэй байдаг. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны арга хэрэгсэл үүнтэй нэгэн адил хөрөнгө оруулалтыг дэмжих болон хөрөнгө оруулалтад хязгаарлалт хийх гэсэн хоёр хэлбэртэй байдаг. Дэмжих болон хязгаарлах арга хэрэгслийн алийг нь хэрэглэх вэ гэдгийг тухайн орны зах зээлийн нөхцөл байдал, эдийн засгийн бодлого гэх мэтээс хамаарч шийднэ.

Хөрөнгө оруулалтыг дэмжих арга хэрэгсэлд нэгдүгээрт, төрөл бүрийн мөнгөн дэмжлэг, улсын/орон нутгийн татвараас хөнгөлөх, гаалийн татвараас хөнгөлөх, хөрөнгийн элэгдэл хорогдлыг тооцох гэх мэт хөрөнгө

оруулалтын инсендив. Хоёрдугаарт, гадаадын иргэний оршин суух байгууламж, эмнэлэг, олон улсын сургууль, соёлын арга хэмжээ гэх мэт бизнесийн тав тухыг хангах арга хэмжээ. Гуравдугаарт, гадаадын хөрөнгө оруулалтын газрын мэдээллийн үйлчилгээ, түншийн зуучлал, хөрөнгө оруулалтын зөвшөөрөл авах, үйлдвэр, компани байгуулахад захиргааны дэмжлэг үзүүлэх гэх мэт нэг цэгт үйлчилгээ. Дөрөвдүгээрт, эрдэм шинжилгээний байгууллага, худалдаа үйлдвэрлэлийн тэнхим, хууль/санхүүгийн компани гэх мэт хөрөнгө оруулалттай холбоотой байгууллагын зөвлөгөө. Тавдугаарт, хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг шийдвэрлэх хэлтэс нээж ажиллуулах, омбудсман систем бий болгох, эцэст нь гадаад руу албан төлөөлөгчөө илгээх, хөрөнгө оруулалтын хурал зөвлөгөөн зохион байгуулах, гадаадын компанийг шагнаж урамшуулах гэх мэт хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа орно.

Хөрөнгө оруулалтын хязгаарлалтанд хөрөнгө оруулагчийн өмчлөх эрх, хөрөнгө оруулалт хийх объектод хязгаарлалт хийх гэх мэт багтана. Дэлхийн олон оронд мэдээлэл харилцаа, эрчим хүч, батлан хамгаалахын салбарыг гадаадын хөрөнгө оруулалт хийгдэх салбарын тооноос хасах юм уу, эдгээр салбарт гадаадын хөрөнгө оруулалт хийгдсэн үед тусгай хуулийн дагуу хөрөнгө оруулагчийн өмчлөх эрхэд хязгаарлалт хийдэг байна. Үүнээс гадна гадаадын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа бодитоор явагдах үед үйлдвэр, компани байгуулах, экспорт импорт, үйлдвэрлэл, үйл ажиллагаа, нийлүүлэлт хийх талаар өргөдөл гаргах, зөвшөөрөл авах, бүртгүүлэх ажлыг олон шат дамжлагатай болгох замаар хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хязгаарлалт хийх нь бий.

■ **Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны арга хэрэгслийг төлөвлөх**

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны орчин болох эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдалд өөрчлөлт оруулахад цаг хугацаа их ордог. Тухайлахад дотоодын зах зээлийн цар хүрээг өргөжүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, технологийн төвшнийг сайжруулах, байгалийн баялаг нээж илрүүлэх, нийгэм улс төрийн тогтвортой байдлыг хангах ажлыг богино хугацаанд амжуулах боломжгүй. Харин хөрөнгө оруулалтын инсендив, гадаадын хөрөнгө оруулалтын газрын үйлчилгээ гэх мэт хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах ажлыг богино хугацаанд хийж болно. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны орчныг бүрдүүлэгч хүчин зүйлс энэ мэт онцлог шинжтэй байдаг бөгөөд үүнийг тусгаж чадах гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны арга хэрэгсэл бол хөрөнгө оруулалтын инсендив юм.

Хөрөнгө оруулалтын инсендивийг ерөнхийд нь мөнгө санхүүгийн инсендив (financial incentive), татварын инсендив (fiscal incentive), зах зээлийн тав тухыг хангах инсендив (market preference)-г хуваадаг.

Татварын инсентивт орлогын татвараас хөнгөлөх, хөрөнгө оруулалт/нэмэлт хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, импортын гаалийн татвараас чөлөөлөх, санхүүгийн төлбөр тооцоо хийх үед хөрөнгийн элэгдэл хорогдлыг тооцох гэх мэт татвараас хөнгөлөх инсентив ордог байхад мөнгө санхүүгийн инсентивт засгийн газрын мөнгөн дэмжлэг, зээлийн баталгаа, хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг засгийн газрын зүгээс хариуцах, хөнгөлөлттэй даатгалд хамруулах гэх мэтээр хөрөнгө оруулалтад шаардлагатай мөнгөн дэмжлэг үзүүлэх тогтолцоо орно. Энэ мэт хөрөнгө оруулалтын зардлыг хувааж төлдөг мөнгө санхүүгийн болон татварын инсентивээс ангид зах зээлийн тав тухыг хангах инсентив гэж хөрөнгө оруулагчийн зах зээл дээрх монополь эрхийг хүлээн зөвшөөрөх, засгийн газрын захиалгат салбарт давуу эрх олгох, бусад компаниудын тухайн зах зээл дээрх үйл ажиллагаанд хязгаарлалт хийх гэх мэт шууд бус аргаар хөрөнгө оруулалтын мөнгө санхүүгийн ашигт баталгаа өгөх инсентивийг хэлнэ.

Гадаадын хөрөнгө оруулалтын эдийн засгийн ач холбогдлыг нэмэгдүүлэх үүднээс инсентивийн объектыг нарийн ангилах хэрэгтэй. Экспортын чиглэлийн хөрөнгө оруулалтын тухайд экспортын хэмжээнээс хамаарч инсентивийн хэмжээг тогтооно. Нэмэлт хөрөнгө оруулалт хийх тохиолдолд нэмэлт хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч татвараас чөлөөлөх жишээтэй. Өндөр хөгжсөн аж үйлдвэрийн салбарын хүрээнд үйлдвэрлэлийн үр бүтээмжид чиглэсэн хөрөнгө оруулалт хийгдэх тохиолдолд бас татварын хөнгөлөлт үзүүлэх жишээтэй. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлогын зорилт эрдэм шинжилгээний салбарыг хөгжүүлэх гэх мэт эдийн засгийн ач холбогдлыг бий болгоход чиглэх үед эрдэм шинжилгээ, судалгааны салбарын хөрөнгө оруулалтад мөнгөн дэмжлэг болон татварын хөнгөлөлтийн аль алинийг үзүүлнэ.

3. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааг чиглүүлж явуулах объектыг тодорхойлох

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны зорилт, түүнд хүргэх арга хэрэгслийг тодорхойлсон бол дараагийн шатанд энэ үйл ажиллагааг ямар объектод чиглүүлж явуулах талаар тодорхойлно. Энэ ажлыг гадаадын хөрөнгө оруулалтын маркетингийн тагет (marketing targeting) хийх гэж тодорхойлох нь ч бий. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааг чиглүүлж явуулах объектод гадаадын хөрөнгө оруулалт хийгдэх шаардлагатай аж үйлдвэрийн салбар, компани болон хөрөнгө оруулалтыг гардаж хийх улс орон багтана.

1) Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааг чиглүүлж явуулах салбарыг тодорхойлох

Хөрөнгө оруулалтын хэрэгцээ, тухайн аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадвар¹⁹, нөхцөл бололцоог²⁰ харгалзаж энэ үйл ажиллагааны объектыг тодорхойлох нь зүйтэй.

2) Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааг чиглүүлж явуулах улс орныг тодорхойлох

Гадаадын хөрөнгө оруулалт хийгдэх шаардлагатай аж үйлдвэрийн салбарыг тодорхойлсон бол уг аж үйлдвэрт хөрөнгө оруулалт хийх улс орныг тодорхойлох бөгөөд энэ үед тухайн орны аж үйлдвэрийн хөгжлийн төвшин, хоёр орны соёлын ижил төстэй тал, газарзүйн байршил (border effects) гэх мэтийн хүчин зүйлсийг харгалзаж үзнэ.

Дүгнэлт

Энэ судалгаагаар гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлогыг “Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааг чиглүүлэх объектыг тодорхойлох, эдгээрт хэрэгтэй хөрөнгө оруулалтыг дэмжиж бий болгох арга замыг боловсруулж хэрэгжүүлэх ажиллагаа” гэж тодорхойллоо. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа нь гадаадын валютын тогтвортой байдал, олон улсын төлбөрийн тэнцэл, ажил эрхлэлт, эдийн засгийн өсөлт гэх мэт макро эдийн засгийн бодлого, аж үйлдвэрийн бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлох аж үйлдвэрийн бодлого, компаний бүтэц, өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн аж ахуйн нэгжийн бодлоготой нягт холбоотой байдаг талаар авч үзлээ. Тиймээс гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлогын зорилтыг эдгээр бодлоготой уялдаатайгаар тодорхойлдог болох, үүнтэй уялдуулж түүнд хүргэх арга хэрэгслийг төлөвлөдөг болох талаар тодрууллаа. Үүнээс гадна гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааг чиглүүлэх объектод гадаадын хөрөнгө оруулалт хийгдэх шаардлагатай аж үйлдвэрийн салбар, компани болон хөрөнгө оруулалтыг гардаж хийх улс орныг багтаагаад хөрөнгө оруулалтын хэрэгцээ, тухайн аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадвар, нөхцөл бололцоог харгалзаж энэ үйл ажиллагааны объектыг тодорхойлох нь зүйтэй болох, хөрөнгө оруулалт хийх улс орныг тухайн орны аж үйлдвэрийн хөгжлийн төвшин, хоёр орны соёлын ижил төстэй тал, хил

¹⁹ Young, S., Hood, N. and Wilson, A., 1994, “Targeting policy as a competitive strategy for European investment agencies”, *European Urban and Regional Studies* 1(2), 143-59.

²⁰ 임성훈, 2002. 7, “지자체의 외국인투자 정책”, *지방의 국제화포럼*, 한국 지방자치단체국제화재단, pp.32-35.

хязгаараар холбогддог эсэх гэх мэтийн хүчин зүйлсийг харгалзаж тодорхойлох ёстой талаар авч үзлээ.

Улмаар хөрөнгө оруулалтыг дэмжигч улс орон нь нэгт, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлого эдийн засаг, аж үйлдвэр, аж ахуйн нэгжийн бодлоготой салшгүй холбоотой байдгаас түүний зорилт, арга хэрэгслийг эдгээртэй уялдуулж тодорхойлох ёстой. Хоёрт, зорилт түүнд хүргэх арга хэрэгсэл хоорондоо яв цав нийцэж байх ёстой. Гуравт, хөрөнгө оруулалтын инсентив зэрэг арга хэрэгслийг төлөвлөхөд анхаархаас илүү гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны орчныг бүрдүүлэгч хүчин зүйлс буюу улс төр, эдийн засгийн нөхцлийг сайжруулах тал дээр түлхүү анхаарах ёстой гэсэн дүгнэлтэд хүрлээ.